

Living the Lotus 10

Buddhism in Everyday Life

2024
VOL. 229



**Тайнан, Тайпэй нийгэмлэгийн хамтарсан
лидерийн сургалт 2024 оны 9 сарын 8-10-нд
Тайванд зохион байгуулагдав.**

Living the Lotus Vol. 229 (2024.10)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Бодь сэтгэлээ хөгжүүлж, дотоод бурхнаа сэргээх нь

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Бурханлаг чанараа гүнзгий ухамсарлах

Шагжамүни бурхан сэтгэлдээ сүсгийн үрийг суулгаж, залхуурч хойрголохгүй түүнийгээ ургуулах аваас “алив зовлонгоос гэтэлнэ” хэмээн айлдсан. Энэхүү сургаал тухайн үед Шагжамүни бурхны өмнө зогсож байсан хүмүүс төдийгүй өнөөгийн бидний зүрх сэтгэлд ч гэсэн гүн сэтгэгдэл төрүүлнө. Бид энэхүү бишрэм сайхан сургаалыг байгаагаар нь хүлээн авч бурхны зам мөрөөр алхахад болох юм.

Гэхдээ “ганц удаа бодь сэтгэлээ хөгжүүлчих юм бол дахиж зовж шаналахгүй” гэж бодох нь хэтэрхий дур зоргоороо ойлголт гэж би өмнөх сарын дугаарт хэлсэн. Өдөр бүр хөрс сийрүүлэх буюу сэтгэлээ зөөллөх үг хэл, үйл хөдлөлөөр бодисадвагийн үйлийг хэрэгжүүлж, тухай бүрт өөрийн дотор орших бурхан, бурханлаг мөн чанараа ил гаргаж байвал амьдралын зовлон багасах болов уу.

Бид хоромхон зуур Бурхантай ижил мөн чанартай өөрийгөө хийгээд өөр хэн нэгнийг олж хараад хүндлэн дээдлэх үе байхад дараах агшинд дахин эргэлзээ төөрөгдөл ундран гарч ирээд мөн чанараа умартчихдаг. Гэхдээ зовлон бэрхшээлтэй тулгарсан хүнд ямар нэг аргаар туслах юмсан гэх учрал тохиох үед өөрийгөө бурханлаг мөн чанартайг санаж, түүнийгээ гүнзгий ухамсарладаг. Ийм туршлага хуримтлуулах чухал.

Энэ сард Үүсгэн байгуулагчийн нирваанд орсон өдрийн ёслол тохиож буй. Тэрээр хүн бүхэн өөрийн болон бусдын бурханлаг чанарыг олж харахын чухлыг үргэлж сургадаг байсан. Бидний сэтгэлийн тулгуур болох Лянхуа судрыг “Хүн бурханлаг чанараа олж анзаарахын чухлыг сургасан судар” гэсэн ба хэн бүхэнд байдаг бурханлаг чанар болох “сайхан сэтгэл, чин сэтгэл, сайн санаа” гэх зэрэг “сэтгэл дэх эрдэнэ”- ээ ил гаргаж байх юм бол үргэлж өөдрөг гэгээлэг, амар амгалан амьдарна гэж сургасан.

Харин эсрэгээрээ бодь сэтгэлээ хөгжүүлэхээ хоромхон зуур умартах төдийд бидний сэтгэл хатаж хорчийн уян хатан чанараа алддаг ба улмаар өөрийн болон бусдын бурханлаг чанар харагдахаа байдаг. Эртний судар бичигт “Өөрийн биед бурханлаг чанар бийг мэддэггүй хүн эгэл хүн болой” гэж тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл үнэндээ хэзээ ч дотоод бурхнаа эргээд сэргээх боломжтой атал эгэл хүмүүн бээр түүнийг мартаж, нисваанисаар дүүрэн өөрийгөө жинхэнэ би гээд бодчихдог ажээ.



Энэрэхүй сэтгэл бурханлаг чанарыг сэргээдэг

Тэгвэл яавал жинхэнэ өөрийгөө олж дотор орших бурхнаа сэргээх вэ гэвэл Үүсгэн байгуулагчийн хэлсэн “бурханлаг чанар гэдэг нь энэрэхүй сэтгэлийг хэлнэ” гэсэн утгатай дээрх үгэнд хариулт нь бий. Өмнө өгүүлсэнчлэн энэрэн нигүүлсэх сэтгэлийг төрүүлж, түүнийг хэрэгжүүлэх болгонд бурханлаг чанар ил гарч ирдэг. Жишээлбэл энгийн үед яагаад ч юм дотор арзгануулдаг аалзыг хараад түүний амь нас өөрийн амь нас лугаа адил нандин болохыг мэдэрч хороохоо больсон гэж бодъё. Энэ нь энэрэн нигүүлсэх сэтгэлээр аалзны бурханлаг чанарыг хүндэлсэн гэсэн үг ба аалзны ачаар өөрийн бурханлаг чанар ч гэсэн ил гарч ирэхийг анзаарах буй за.

Ийнхүү бурханлаг чанараа бага багаар гүнзгий мэдрэхийн хажуугаар сэтгэлд таагүй зүйл тохиолдохоор бид өөрийн мэдэлгүй үглэж гомдоллон, уурлаж уцаарлан, хэн нэгэнд хүйтэн хөндий үг хэлчихдэг. Тийм уужуу сэтгэлгүй өөрийгөө бурханлаг чанараа анзаарсан үеийн өөрөөсөө хол зөрүүтэй байгаад ичиж, шаналах хүн ч байж болох юм.

Хэдий тийм ч гэсэн “над шиг хүн бурханлаг чанараа анзаарна гэж бүтэхгүй юм байна” гэж сэтгэлээр унах хэрэггүй. Эртний өндөр зэрэг дэвтэй хувраг хүртэл “Надад агуу гэгээрэл 18, өчүүхэн гэгээрэл хязгааргүй олон байсан” гэж өгүүлсэн байдаг. Тэр хувраг ухаарал, эргэцүүллийг ээлжлэн ямагт “Бурхан лугаа адил амьдрахсан” хэмээн бодь сэтгэлээ хөгжүүлдэг байсан гэдэг. Тиймээс харин ч өөрөөсөө ичих сэтгэлээр дамжуулж олж анзаарсан зүйл тань өсөж хөгжих, өөдөө ахих шат болох юм. Түүнчлэн “хамаг амьтан бүхэн бурханлаг чанартай” хэмээх үгийг ойлгох ухаантай хүн болсондоо талархаж, элдэг нинжин сэтгэлийг мартахагүй байх нь юу юунаас ч илүү чухал билээ.

Үүсгэн байгуулагч “Хүмүүсийг баярлуулах үйлийг хийгээд байхаар бидэнд заяасан агуу энэрэн нигүүлсэх сэтгэл, бурханлаг чанар гэдэг зүйл улам бүр гэрэлтэн гялалзаж, хэн нэгний бурханлаг чанар өөр нэгний бурханлаг чанарыг сэргээх Бурханы ертөнц бий болно” гэж хэлсэн. Тиймээс бидэнд төрөлхийн өөрийгөө алив зовлонгоос ангижируулах чадвар байдаг гэдэгт би итгэдэг.

“Косей” сэтгүүл, 10-р сарын дугаараас



Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Нийгэмлэгийн тэмдэглэлт баяр ёслолууд

Шинэ оны айлдвар

Энэхүү ёслол нь шинэ оны 1-р сарын 7-нд Их Ариун Ордонд болдог. Энэ өдөр Рисшо Косей Кай нийгэмлэгийн ерөнхийлөгч тухайн жилийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг орон даяар гишүүддээ танилцуулж мөн шинэ ондоо ямар сэтгэлийг эрхэмлэвэл зохилтойг айлддаг.

Ерөнхийлөгчийн удирдамжийг улс даяарх бүх нийгэмлэгт мэдээгээр дамжуулдаг.

Гишүүд Их Ариун Ордон, салбар нийгэмлэгтээ цугларч, ерөнхийлөгчийн удирдамжийн дагуу тухайн жилийн зорилгоо шинээр тодорхойлдог.



Бяцхан мэдлэг

1-р сарын 7-ны өдрийг "Долоо дахь өдрийн шинэ жил" гэж нэрлэдэг бөгөөд шинэ жилийн баярын төгсгөл гэж үзэн хүмүүс хэвийн амьдралдаа эргэн ордог. Мөн яншуй, зэрлэг гайм зэрэг долоон төрлийн ногоогоор амталсан "нанакүсагаюү" хэмээх будааны зутан идэж, бүтэн жилийн турш эрүүл энх байхын төлөө залбирдаг.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Өвлийн номын уншлага



Хүйтний эрч орохоос эхлэн (1-р сарын 20) Сэцүбүн баяр (2-р сарын 3) хүртэл гишүүд Их Ариун Ордон болон орон даяарх салбар нийгэмлэгтээ цугларч Гурван эрдэнийн Цагаан лянхуа судрыг уншдаг. Уншлага өглөөний 6 цагаас эхлэдэг ба 15 хоногийн турш үргэлжилдэг.

Жилийн хамгийн хүйтэн үед өглөө эрт босох нь маш хэцүү байдаг ч хийж чадсаны дараа мэдрэх баяр баясгалан, сэтгэл ханамжийн мэдрэмж танд урьд өмнө байгаагүй их хүчийг өгнө. Түүнээс гадна бүх зүрх сэтгэлээ зориулан судар уншсанаар сэтгэл сэргэж өөдрөг болдог.

Бяцхан мэдлэг

Сэцүбүн гэдэг нь “улирал солигдох” гэсэн үгийн товчлол юм. Энэ өдөр айл бүр "Аз жаргал наашаа, ад чөтгөр цаашаа." гэж чанга дуугаар хэлэн буурцаг шидэж муу сэтгэлээ хөөн зайлуулдаг заншилтай.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

Эрүүл мэндийн үзлэгээс суралцсан тухай

Акагава Кэйичи

Та бүхний амгаланг эрье. 10-р сар гарч Японд намрын ургац хураалтын улирал эхэллээ.

Энэ сард бид “Бурханлаг чанараа анзаарах нь” гэсэн сэдэвтэй айлдварыг хүлээн авлаа. Та бүхэн ямар үед өөрийн бурханлаг мөн чанарыг анзаардаг вэ? Саяхан надад тохиолдсон зүйлд тулгуурлан энэ сэдвээр ярилцъя гэж бодлоо.

Би эрүүл мэндийнхээ төлөө жил бүр эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамрагддаг. Энэ удаагийн үзлэгийн дараа миний бөөрөнд нарийн шинжилгээ хийх шаардлагатай гэсэн мэдэгдэл ирсэн бөгөөд түүн дээр “Хэрэв одоогийн нөхцөл байдлыг тоохгүй орхиж хүндрэх юм бол бөөр шилжүүлэн суулгах эсвэл гемодиализийн эмчилгээ хийх шаардлагатай болно” гэж бичсэн байв. Цочирдсон би тэр даруй нарийн шинжилгээ хийлгэж, эмчээс хариугаа сонслоо.

Эмч “Аз болоход шинжилгээний хариу нь эмчилгээ шаардах хэмжээнд биш байна.—Гэхдээ давс багатай, тэнцвэртэй хоол идэж, зохих дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж байхыг зөвлөж байна. Харихдаа хооллолтын мэргэжилтэнтэй уулзаарай” гэсэн зааварчилгаа өгөв.

“Хаягдал бодисыг гадагшлуулах, биеийн давсны концентрацийг зохицуулах, биеийг бага зэрэг шүлтлэг байлгах” гэх мэт бөөрний үйл ажиллагаа бүрийг аваад үзвэл тэнд хором бүрт амьдралын гайхамшигтай үйл ажиллагаа явагддаг нь эргэлзээгүй. Дахин шинжилгээ өгсөн завшаанаар “Амьд явах хүсэл эрмэлзэл буюу бурханлаг мөн чанараа даган амьдрах болно” гэж би тангарагласан.

Мөн айлдварт сургасны дагуу бусдыг баярлуулах үйлийг давтан хийж, өөрт заяасан бурханлаг мөн чанарыг улам гэрэлтүүлж, энэ сард ч гэсэн эелдэг, сайхан сэтгэлээр бурхны үйлийг хэрэгжүүлэх болно.



Гадаадын гишүүд олон улсын хэлтэст мэндэлэхээр ирэв.

Дээд талд: Нью-Йорк салбарын гишүүд (арын эгнээний голд) -ийг угтан авсан Акагава хэлтсийн дарга ба олон улсын хэлтсийн ажилчид.


Доод талд: Улаанбаатар салбарын гишүүнтэй ярилцаж буй Акагава хэлтсийн дарга.

Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp